



СОЁМБОМ

МОНГОЛ УЛСЫН ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

МЭДЭЭ

№101 /545/

2023.06.21

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

Цаг үе, үйл явдал


МОД, БУТ, СӨӨГ ТАРИХ АРГА, ТЕХНОЛОГИЙН ЦАХИМ СУРГАЛТ ЯВАГДЛАА



Цахим сургалтыг эхэнд “Тэрбум мод” тарихын ач холбогдол, Дэлхийн дулаарал, цаг уурын өөрчлөлт, манай орны экологийн одоогийн нөхцөл байдал, цөлжилт, ойн фондын хомсдол, түүнд нөлөөлж байгаа хүчин зүйлүүдтэй холбогдуулаад Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч У.Хүрэлсүх НҮБ-ын 76 дугаар чуулганы индэр дээрээс уриалсан “Тэрбум мод”-ны талаарх танилцуулгыг хийлээ.

Сургалтаар хот суурин газрын ногоон байгууламж, тарималжуулах мод ургамлыг ойгоос болон мод үржүүлгийн газраас сонгох, ухаж авах, тээвэрлэх, тарималжуулах, суулгах, услах, арчлах арга ажиллагааны технологи, хашааг цэцэрлэгжүүлэхэд юунд анхаарах, экологид ээлтэй амьжиргаанд чанартай хашааны тухай, албан байгууллага орчны цэцэрлэгжилтийн стандарт, норм норматив, мод үржүүлгийн газрыг хаана хэрхэн байгуулах, түүний зохион байгуулалт, тэнд эхний ээлжид тарьж суулгах мод сөөгийг сонгох, Монгол оронд ургаж буй мод сөөг, түүний зүйлийн бүрэлдэхүүн, мод ургамал тус бүрийн шинж чанар, ургах орчин нөхцөл, хэрхэн сонгож тарьж суулгах арга ажиллагааны онцлог бүрийг зураг дээр тайлбарлан танилцуулсан юм.

Мөн жимс, жимсгэнийг тариалах, чацаргана, үхрийн нүд болон бусад жимсний модны арчилгааны талаар нийт 9 төрлийн сэдвийн хүрээнд 16 цагийн сургалтыг анхны мэдэгдэхүүн, анхаарах зүйл, цаашид хэрэгжүүлэхэд анхаар зүйлсийг тайлбарлан таниуллаа.



Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, салбарын 300 гаруй алба хаагчдад мод, бут, сөөгийг арчлан хамгаалах мод үржүүлгийн газрын зохион байгуулалт, үрээр үрсэлгээ хийхэд анхаарах

асуудал, усалгаа, арчилгааг хийх арга, технологи гэсэн 9 сэдвийн хүрээнд энэ сарын 16, 19-ний өдрүүдэд цахим сургалтыг явууллаа.

Цахим сургалтыг Монгол Улсын Байгаль орчны гавьяат ажилтан, Биологийн ухааны доктор, профессор, дендрологич Бадрахын Чимидээр заалгаж, зохион байгууллаа.

“ЗУУН МОД МАРАФОН-2023” ГҮЙЛТИЙН ТЭМЦЭЭНД АМЖИЛТТАЙ ОРОЛЦЛОО



Төв аймгийн Зуун мод сумын 81 жилийн ойн хүрээнд зохион байгуулагдсан “Зуун мод марафон-2023” гүйлтийн тэмцээнд Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлийн цэргийн алба хаагчдын төлөөлөл амжилттай оролцлоо.

Гүйлтийн тэмцээний 35-40 насны 10 километрийн төрөлд тус нэгтгэлийн Мотобуудлагын батальоны Хангалт үйлчилгээний салааны тээврийн тасгийн захирагч ахлах ахлагч Б.Отгонтуяа тэргүүн байрт шалгарч алтан медаль, 30-35 насны 10 километрийн төрөлд Авто техникийн албаны нярав засварчин дэд ахлагч Ж.Эрдэнэбат дэд байрт шалгарч мөнгөн медаль хүртсэн амжилт үзүүлж, цэргийн алба хаагчийн бие бялдар, тэсвэрийн чанар чансааг иргэд, олон түмэнд тодоор харууллаа.

Хошууч О.ГЭРЭЛЗАЯА

СЭТГЭЛ ЗҮЙН МЭДЛЭГИЙГ ДЭЭШЛҮҮЛСЭН СУРГАЛТААР...



Жанжин Д.Сүхбаатарын нэрэмжит Байлдааны гавьяаны улаан тугийн одонт Зэвсэгт хүчний 336 дугаар ангид энэ сарын 21, 22-ны өдрүүдэд ЗХЖШ-ын даргын тушаалаар томилогдсон “Сэтгэл зүйн хөдөлгөөнт бүлэг” ажиллалаа.

Зэвсэгт хүчинд алба хааж буй офицер, ахлагч, ажилтан албан хаагч, цэргийн гэрээт болон хугацаат цэргийн алба хаагчдын сэтгэл зүйн тогтвортой байдлыг хангах, сэтгэл зүйн бэлтгэлжилтийг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилготой сэтгэл зүйч нар бие бүрэлдэхүүнээр сонирхолтой олон дасгал ажил гүйцэтгүүлж, сэтгэл зүйн мэдлэгийг дээшлүүлсэн сургалтыг амжилттай зохион байгуулав.

Нарийн мэргэжлийн эмч нарын адил, хүрэлцэн ирсэн сэтгэл судлаачдад нийт бие бүрэлдэхүүн талархал илэрхийлж, халуун алга ташилтаар урам өгч, ажлын өндөр амжилт хүсэн ерөөлөө.

Ахмад А.АЛТАНХУЯГ



ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 27	☁️ 10

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 39	☁️ 25

ВАЛҮТЫН ХАНШ

ВАЛҮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	3,429	3,437
EUR 🇪🇺	3,738	3,777
CNY 🇨🇳	485	488
RUB 🇷🇺	39.20	40
JPY 🇯🇵	24.25	24.75
KRW 🇰🇷	2.30	2.45

ЗУРХАЙ

2023.06.21 /ЛХАГВА ГАРАГ/ БИЛГИЙН ТООЛЛЫН 3

ЗУНЫ ДУНД ШАР МОРЬ САР ЗУРГААН ЦАГААН МЭНГЭТЭЙ ЦАГААН НОХОЙ ӨДӨР

Үс засуулбал:
Эд мал баялаг төгөлдөр болно
Наран ургах, шингэх:
04.53-20.55
Барилдлага:
Үхэх
Шүтэн барилдлага:
Хурьцахуй

Тухайн өдөр гахай, хулгана, үхэр, луу, нохой жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба могой, морь жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Өдрийн сайн цаг нь бар, луу, могой, бич, тахиа, гахай болой. Эл өдөр амь таслах, хор найруулах үйлнээ зэрэгчлэн бүтнэ, бурханы үйл, хувцас хийхэд сайн. Зүүн нүд татвал хувцас олох, баруун чих цангинавал үзэсгэлэн болох, зүүн нь бол үхэл болсныг сонсох, нохой уливал сонсголонтой үг сонсох, тагнай загатнавал гэр арвидах, бие татвал 1-2 хүн ирэх, хөл татвал гомдол аюул болно.

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 690,600,263

Эдгэрсэн

Нийт: 663,057,141

Нас барсан

Нийт: 6,891,661

Цахим шууданд

СЭТГЭЛ ЗҮЙН ХӨДӨЛГӨӨНТ БҮЛЭГ СҮХБААТАР АЙМАГТ АЖИЛЛАЖ БАЙНА



тодотголоо.

Үүний дараа бүлгийн багш нар ангийн офицер, ахлагч нарыг нийт 9 бүлэгт хуваарилан үндсэн 3 хэсгээс бүрдсэн сэтгэл зүйн мэдлэгийг дээшлүүлэх сургалтыг шинэлэг арга хэлбэрээр зохион байгуулсан юм.

Тус сургалтын хүрээнд “Хувь хүний багт гүйцэтгэх үүрэг, оролцоо”, “Харилцааны сэтгэл зүй”, “EQ”, “Сэтгэл гутралын шинж тэмдэг, түүнээс сэргийлэх болон гарах арга зам” зэрэг олон төрлийн оношилгоо сургалтыг зохион байгуулж, бие бүрэлдэхүүн өөрийн давуу болон сул талаа мэдэх, цаашид хөгжүүлэхэд нэмэр болохуйц үр дүнтэй сургалт болсон юм. Мөн алба, салбар тус бүрээр хамт олны уур амьсгал, хоорондын харилцааг бэхжүүлэх зорилгоор бүлгийн зөвлөгөө зохион байгуулсан нь тус сургалтын нэг онцлог байсан юм.

Сургалтыг зохион байгуулагчдад ангийн удирдлагууд талархсанаа илэрхийлж сэтгэл зүйн тогтвортой байдал, итгэл үнэмшил гэдэг цэргийн хүнд хамгийн чухал байдгийг онцолж, хичээлээр олж авсан мэдлэгээ ажил, амьдрал дээрээ хэрэгжүүлэхийг бүрэлдэхүүнд захисан юм.

Ахмад С.ЭНХСОЁЛ

ЗХЖШ-ын даргын тушаалаар томилогдсон “Сэтгэл зүйн хөдөлгөөнт бүлэг” Зэвсэгт хүчний 338 дугаар ангид ажиллаж байна.

Бүлгийн удирдагч Зэвсэгт хүчний Жанжин штабын Суртал хүмүүжил, сэтгэл зүйн хангалтын хэлтсийн дарга, хурандаа Ү.Хүрлээ Зэвсэгт

хүчинд алба хааж буй офицер, ахлагч, ажилтан албан хаагч, цэргийн гэрээт болон хугацаат цэргийн алба хаагчдын сэтгэл зүйн тогтвортой байдлыг хангах, сэтгэл зүйн бэлтгэлжилтийг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх хүрээнд нэгтгэл, ангиудад ажиллаж байгааг онцолж, цаашид гарах үр дүнг нь

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ОЮУТАН, ЗАЛУУС ЦЭРЭГЖЛИЙН БЭЛТГЭЛ СУРАЛТАД ХАМРАГДАЖ ЭХЭЛЛЭЭ



онцлог.

Харин тус сургалтад Дархан-Уул аймгаас татагдсан 45 оюутан, залуусыг Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн сургалтын төвийг түшиглэн цэргийн мэргэжлийн бэлтгэл сургалтад хамруулж эхэллээ.

Тус аймагт оюутан-цэрэг хөтөлбөр анх удаа хэрэгжиж байгаа бөгөөд “Хүний ёсоор хандаж цэргийн ёсоор сургана” гэсэн уриан дор хөнгөнөөс хүнд багаас ихрүү” гэсэн зарчмаар сургалт явагдаж байна.

Оюутан залууст цэрэг-эх оронч үзлийг суулгах, тэднийг цэргийн хэргийн мэдлэгтэй болгож дадлагажуулах зорилгоор анх 2014 оноос хэрэгжиж эхэлсэн “Оюутан цэрэг” хөтөлбөр, сургалт өнөөдрийг хүртэлх хугацаанд амжилттай үргэлжилж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн хуралдаанаас “Оюутан цэрэг” сургалтад 1500 оюутан, суралцагчийг хамруулах шийдвэр гарсан. Уг шийдвэрийн дагуу

Энэ жилийн “Оюутан цэрэг” сургалтад хот, хөдөө, орон нутгийн их, дээд сургууль, коллеж, МСҮТ-ийн оюутан, суралцагчид оролцож буйгаараа



Санамж

Зэвсэгт хүчний Жанжин штаб

ЖОЛООЧИД ДАРААХ ЗҮЙЛСИЙГ ХОРИГЛОНО

Цагдаагийн ерөнхий газар

ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ ДҮРЭМ

- тээврийн хэрэгслийн хөдөлгөөний үед гар утас болон түүнтэй ижил төстэй төхөөрөмж, хэрэгслийг гарны оролцоотойгоор ашиглах;
- зохицуулагчийн шүтлийн чимээ, бусдын дуут дохиог сонсох боломжийг хязгаарласан чихэвч зүүх, хэт чанга хөгжим дуугаргах;

ЗХД-ийн 3.7 дахь заалт

ГОВИЙН БҮСИЙН ОЮУТАН ЦЭРГҮҮД ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 167 ДУГААР АНГИД ...



Энэ жил Монгол Улсын Засгийн газрын шийдвэрийн дагуу “Оюутан цэрэг” сургалтад хамрагдах залуусын тоог 1500 болгож нэмэгдүүлсэн ба үүний 425 суралцагч нь орон нутгийнх билээ.

Говийн бүсийн аймгуудын хэмжээнд анх удаа “Оюутан цэрэг” сургалт Зэвсэгт хүчний 167 дугаар ангийг түшиглэн зохион байгуулагдаж, Өвөрхангай, Баянхонгор, Архангай, Говьсүмбэр, Дорноговь, Өмнөговь, Дундговь аймгийн оюутан, суралцагч нар хамрагдаж байна.

Зэвсэгт хүчний 167 дугаар ангийн захирагчийн сургалт бэлтгэл хариуцсан орлогч дэд хурандаа Е.Бейбит оюутан цэргүүдийг угтан авч амжилт хүсэхийн зэрэгцээ салаа

салбарт нь шинэ дайчдыг хуваарилж хүлээлгэн өглөө.

Тэрээр хэлэхдээ бид говийн бүсэд анх удаа “Оюутан цэрэг” сургалтыг хэрэгжүүлж байна. Та бүхэн үеийн нөхдөө сурлага хөдөлмөр ур чадвараараа манлайлан шалгаран ирсэн, энэ манлайлаа ч хадгалж яваарай. Хэдий богино хугацаанд ч гэсэн цэргийн 11 төрлийн мэргэжил эзэмшиж, хувь хүний зохион байгуулалт, тэсвэр, хатуужил, сэтгэлийн хат сууж эргээд үе тэнгийн залуусын дунд очихдоо энэ чанараараа тод ялгарна гэж онцлов. Үүний дараа цэргийн алба, сурлага хөдөлмөрт нь өндрөөс өндөр амжилт хүслээ.

Ахлах дэслэгч Б.БАТЗАЯА



ХИМИЧИН ДАЙЧИД 400 ОЮУТАН ЦЭРГИЙГ УГТАН АВЛАА



“Оюутан цэрэг-2023” сургалт өнөөдөр цэргийн мэргэжлийн бэлтгэлээр үргэлжилж байна. Энэ жил Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр оюутан цэрэгт хамрагдах залуусын тоог 1500 болгож нэмэгдүүлсэн бөгөөд нийслэлийн хэмжээнд 1165, орон нутагт 425 суралцагч шалгаруулалтад тэнцэж сургалтад хамрагдаж байна.

Тэгвэл 1500 суралцагчаас Улаанбаатар хүрээний их, дээд сургуулийн 400 оюутан цэрэг нь Зэвсэгт хүчний 119 дүгээр ангийн Сургалтын төвд цэргийн мэргэжлийн бэлтгэл сургалтад хамрагдах юм.

Зэвсэгт хүчний ХЗКЦ-

ын Химийн дарга, дэд хурандаа Н.Гэрэлбадрах болон тус ангийн удирдлагууд оюутан цэргүүдийг угтан авч амжилт хүсэхийн зэрэгцээ зааварчилгаа хүргэв. Тэд “Энд цугларсан та бүхэн бол үе тэнгийнхнээсээ сурлага хөдөлмөр, харилцаа хандлагаараа шалгарсан шилдэг залуус. Та бүхэн энэхүү сургалтад хамрагдсанаар цэргийн 11 төрлийн мэргэжил эзэмшихээс гадна хувь хүний зохион байгуулалт, тэсвэр, хатуужил, бие бялдрын хөгжил гээд олон чавдарыг олж авна” хэмээгээд амжилт хүссэн юм.

Хошууч Б.ТЭГШБАЯР